

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны
санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн хураангуй
тайлан

АУДИТЫН КОД:

ДУА-2026/01/НА-СТА-ТЕЗ

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225

Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113

Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn

Аудитор Э.Пүрэвбаатар
Цахим хаяг: Purevbaatare@audit.gov.mn
Утас: 7059-3113

Цахим хаяг: Dundgovi@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn



1. ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 8/10

Мандалговь

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 18 дугаар зүйлийн 9, 2023 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.“Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн аудитын тайланг (ДУА-2026/01/НА-СТА-ТЕЗ)-г нэгдүгээр хавсралтаар, аудитаар илэрсэн зөрчил, төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагад хүргүүлсэн төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, улсын төсвийн байгууллагад хүргүүлсэн төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3.Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан үр дүнгийн талаар 2026 оны 09 сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт харну ирүүлэхийг аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун), Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Сүхбаатар), Ерөнхий санхүүч (С.Адьяасүрэн)-д тус тус зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2026 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын нэгдүгээр нэгжийн ахлах аудитор (Ж.Угтахбаяр), аудитор (Э.Пүрэвбаатар) нарт үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

4826010022



Агуулга

1.	Тайлан баталгаажуулах тушаал	1
1.	Хараат бус аудиторын дүгнэлт	3
2.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайан	7
2.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3.	Аудитын илрүүлэлт	9
3.1	Төлбөрийн акт.....	11
3.2	Албан шаардлага.....	11
4.	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14
4.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БХС	Байгаль хамгаалах сан
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
СДОА	Сум дундын ойн анги
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчийн Хурал
МХС	Мал хамгаалах сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ӨЭМТ	Өрхийн Эрүүл мэндийн төв
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗС	Тусгай зориулалтын сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч



1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сүм
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.04.22 № 114

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА С.МӨНХЧУЛУУН
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Дундговь аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар “Хязгаарлалттай” дүгнэлт авсан (*Баянжаргалан, Сайнцагаан, Өлзийт, Хулд сумдын нэгтгэсэн санхүүгийн тайлан, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар, “Мандалын гэгээ ХТГ” ОНӨААТҮГ*) нийт 6 санхүүгийн тайлан нь дүгнэлт гарсан байгууллагуудын 16.7 хувийг эзэлж байна.

Төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн авлага, өр төлбөрийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй, үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй, эд хөрөнгийн тооллого хийгээгүй, тооллогыг чанаргүй хийсэн, албан хаагчдад цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг зөрүүтэй тооцож олгосон, төсвийг зориулалт бусаар үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан зэрэг 3,744.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь материаллаг дүнтэй боловч санхүүгийн тайланд өргөн тархаагүй.

Эдгээр залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 4.6 дахин их байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох заавар журмын заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4826050407



Асуудлыг онцолсон хэсэг

Дундговь аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн заавар журамтай холбоотой дараах зөрчил нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу тайлагналын эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байлаа.

1. ТЕЗ-ийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүнг өмнөх онтой харьцуулахад нийт зөрчил 1,195.9 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Тодруулбал залруулсан алдаа 5,654.6 сая, төлбөрийн акт 134.8 сая, хариуцлага тооцуулах албан шаардлага 272.7 сая төгрөгөөр буурч, зөвлөмж 3,204.6 сая төгрөгөөр, албан шаардлага 1,116.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт зөрчлийн 88.5 хувийг албан шаардлага, зөвлөмж эзэлж байна.
2. Адаацаг, Баянжаргалан, Дэлгэрцогт, Сайнцагаан, Хулд, Цагаандэлгэр, Өлзийт, Өндөршил зэрэг 8 сумын хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг нөхөн төлүүлэхээр 66.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.
3. Иргэдээс төвлөрүүлсэн нүүрсний тээвэрлэлттэй холбоотой 561.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд, байгууллагын зохион байгуулалттайгаар хэрэгжсэн үйл ажиллагаатай холбоотой байхад тухайн жилийн санхүүгийн тайланд орлого, зардлын хэлбэрээр бүрэн тусгагдаагүй нь Төсвийн тухай хуулийн 25.7-д (*Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана*) заасныг зөрчиж санхүүгийн тайлагналын үнэн зөв, иж бүрэн байдлыг хангаагүй.
4. Өмнөх аудитаар өгсөн 301.5 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн.
5. Төсвийн захирагч нь харьяа байгууллагын санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийлгэх үүрэгтэй боловч Архивын хэлтсийн санхүүгийн тайланг аудитаар оруулаагүй нь Төсвийн тухай хуулийн 8.9.1-т (*... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх*) заасныг зөрчиж, санхүүгийн тайлагналын иж бүрэн байдлыг хангаагүй.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой



зүйлийн талаар тодруулахад Сангийн яамнаас Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын орон тоог Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний дагуу 472 байхаар хянасныг 489 төрийн албан хаагчтай байхаар баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дундговь аймгийн Засаг дарга Засгийн газрын хэрэг эрхлэх газартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс хийсэн үнэлгээгээр 91.7 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,911,395.6	69,857,934.7
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	48,377,572.4	39,635,361.5
3	1.1.3 АВЛАГА	11,206,642.1	10,443,107.2
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	2,275.0	-
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	5,254,128.7	7,550,379.7
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	78,804.0	378,366.0
7	1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,991,973.3	11,850,720.3
8	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	115,689,434.0	124,109,526.8
9	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	115,689,434.0	124,109,526.8
10	1.2.2.02 Биет хөрөнгө	91,367,901.0	99,784,343.9
11	1.2.2.03 Биет бус хөрөнгө	24,321,533.0	24,325,183.0
12	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	182,600,829.6	193,967,461.5
13	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	17,712,657.6	19,071,470.0
14	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,846,812.3	6,314,204.4
15	2.1.1.03 Өглөг	2,224,481.0	5,794,637.4
16	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	1,622,331.3	519,567.0
17	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,865,845.3	12,757,265.5
18	2.1.2.02 Урт хугацаат зээл	13,865,845.3	12,757,265.5
19	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	164,888,172.0	174,895,991.5
20	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	164,888,172.0	174,895,991.5
21	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	49,869,853.9	50,871,728.8
22	2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		6,793,966.5
23	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	87,447,535.5	89,677,199.1
24	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,570,782.6	27,553,097.1
25	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	182,600,829.6	193,967,461.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	107,506,526.3	79,935,667.6
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	43,032,681.9	57,097,778.3
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	37,534,769.5	42,754,244.6
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	15,503,300.1	16,713,149.3
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(601,820.0)	(785,141.0)
6	1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар	22,633,289.4	26,826,236.3
7	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	1,827,085.4	2,574,391.7
8	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	3,670,827.0	11,769,142.0
9	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,255,197.8	22,837,889.2
10	1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	142,111.7	42,497.7
11	1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	2,280,474.8
12	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,218,646.6	-
13	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	51,704,487.3	55,966,122.8
14	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	51,704,487.3	55,966,122.8
15	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,017,978.5	51,041,098.2
16	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,248,949.2	16,786,148.4
17	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,601,873.7	2,638,008.6

ДУА-2026/1/НА-СТА-ТЕЗ



18	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,992,222.2	9,799,682.0
19	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	1,485,867.5	1,498,502.1
20	1.1.2.01.1.05 Нормативт зардал	125,032.1	159,485.8
21	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	1,197,989.2	1,730,750.8
22	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	466,483.1	481,738.1
23	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,766,950.6	4,962,786.8
24	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	14,132,611.0	12,983,995.5
25	1.1.2.01.2 ХҮҮ	628,987.6	-
26	1.1.2.01.3 ТАТААС	3,128,349.1	1,265,534.1
27	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,929,172.1	3,659,490.5
28	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	55,802,039.0	23,969,544.8
29	1.2.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	16,362.8	189.5
30	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,411,546.9	21,166,883.8
31	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(18,395,184.1)	(21,166,694.3)
32	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	37,406,854.9	2,802,850.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	106,091,918.6	83,792,281.3
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	43,095,764.8	57,097,778.3
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	37,534,740.7	42,754,244.6
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(601,820.0)	(785,141.0)
5	1.1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар	22,633,289.4	26,826,236.3
6	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	1,827,085.4	2,574,391.7
7	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	3,733,938.7	11,769,142.0
8	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	555,683.6	5,652,504.3
9	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	1,894,190.4	4,244,217.7
10	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,282,924.8	1,872,420.1
11	1.1.1.1.03.8.04 Бусад татвар	1,140.0	-
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	60,888,397.3	26,694,503.0
13	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	27,191,622.0	11,463,434.8
14	1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	142,111.7	42,497.7
15	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	24,103.6	2,413,857.6
16	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	33,530,560.1	12,774,713.0
17	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,107,756.4	-
18	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,758,661.0	53,563,646.5
19	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	49,758,661.0	53,563,646.5
20	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,157,498.8	48,197,421.2
21	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,405,707.5	19,711,263.7
22	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,079,969.2	2,637,159.4
23	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,583,354.9	11,356,134.2
24	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	3,862,042.8	2,244,404.2
25	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	208,553.0	134,434.8
26	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	1,243,449.6	1,645,814.1
27	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	466,335.5	356,370.7
28	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,176,583.3	4,709,341.7
29	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	7,131,503.1	5,402,498.5
30	1.1.1.2.01.2 ХҮҮ	628,987.6	-



31	1.1.1.2.01.3 ТАТААС	3,036,613.8	1,221,443.3
32	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,935,560.8	4,144,782.0
33	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	56,333,257.5	30,228,634.8
34	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	22,939,190.3	36,304,549.3
35	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,939,190.3	36,304,549.3
36	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	22,939,190.3	36,304,549.3
37	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(22,939,190.3)	(36,304,549.3)
38	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,147,049.5	2,666,296.5
39	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(1,147,049.5)	(2,666,296.5)
40	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	32,247,017.8	(8,742,211.0)
41	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,130,554.6	48,377,572.4
42	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	48,377,572.4	39,635,361.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,936,316.3		124,936,316.3
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,681,019.2)		(2,681,019.2)
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,255,297.1		122,255,297.1
4	1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(148,896.5)		(148,896.5)
5	1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(8.7)		(8.7)
6	1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт	5,374,925.2		5,374,925.2
7	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	37,403,199.2		37,403,199.2
8	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,884,516.3		164,884,516.3
9	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	164,884,516.3		164,884,516.3
10	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(667,928.0)		(667,928.0)
11	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,216,588.3		164,216,588.3
12	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(13,843.4)		(13,843.4)
13	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	6,000.0		6,000.0
14	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	7,884,396.2		7,884,396.2
15	1.7 Тайлант үеийн үр дүн	2,802,850.5		2,802,850.5
16	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	174,895,991.5		174,895,991.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөг/

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
1	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	119,577,214.40	82,469,773.80
2	НИЙТ ЗАРЛАГА	114,980,782.30	81,434,333.80
3	УРСГАЛ ЗАРДАЛ	58,609,526.10	47,005,445.40
4	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,084,139.20	40,510,686.00

ДУА-2026/1/НА-СТА-ТЕЗ



5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,187,164.70	16,494,531.40
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,314,501.90	1,987,380.10
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,714,483.50	10,375,263.80
22	Хангамж, бараа материалын зардал	1,055,039.70	700,782.40
29	Нормативт зардал	141,472.90	122,398.10
32	Эд хогшил, урсгал засварын зардал	2,163,394.80	1,673,729.30
36	Томилолт, зочны зардал	466,741.30	346,140.10
38	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,505,624.90	4,080,849.50
45	Бараа үйлчилгээний бусад зардал	8,535,715.50	4,729,611.40
48	ХҮҮ	1,630,856.50	-
50	ТАТААС	2,492,616.80	2,492,616.80
53	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,401,913.60	4,002,142.60
54	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,935,359.90	2,800,253.40
56	Бусад урсгал шилжүүлэг	1,466,553.70	1,201,889.20
62	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	56,371,256.20	34,428,888.40
64	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	4,596,432.10	1,035,440.00
66	ЗАРДЛЫН САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	119,577,214.40	84,181,572.50
67	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,039,842.00	12,774,713.00
69	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	90,252,954.20	67,241,431.10
71	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,284,418.20	4,165,428.50
75	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	11,096,205.20
76	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	12,808,003.90

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,735,149.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,735,149.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,735,149.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,382.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,738.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,470.40
2104	Хангамж, бараа материалын зардал	83,689.00
2105	Нормативт зардал	7,990.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,420.90
2107	Томилолт, зочны зардал	8,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	580,654.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	702,853.70
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,162,156.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,162,156.40
350011	Хандив, тусламж	465,315.10
350014	Дээд шатны төсөв захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарласан хөрөнгө	694,969.40
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт хөрөнгө	1,001,871.90
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	427,007.30
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын илрүүлэлт

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 37 төсвийн байгууллага, 6 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 32 тусгай зориулалтын сан, 15 сумын нэгтгэсэн тайлан нийт 90 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн. Аудитад хамрагдсан харьяа



байгууллагуудаас 54 байгууллагыг түүвэрт хамруулж, 36 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнд: “Өөрчлөлтгүй” 30, “Хязгаарлалттай” 6 дүгнэлт өгсөн.

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 14,671.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,259.2 сая төгрөгийн 72 алдааг аудитын явцад залруулж, 134.2 сая төгрөгийн зөрчилд 33 төлбөрийн акт тогтоож, 8,801.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 128 албан шаардлага, 4,174.4 сая төгрөгийн 38 зөрчилд зөвлөмж, өмнөх аудитаар өгсөн 301.5 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн. Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 91.5 хувийг залруулагдаагүй, 8.5 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Сумдын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн төвлөрүүлэн захирагчийн 15 санхүүгийн тайланд аудит хийж “Өөрчлөлтгүй” 11, “Хязгаарлалттай” 4 /Баянжаргалан, Сайнцагаан, Өлзийт, Хулд сумдын санхүүгийн нэгтгэсэн тайлан/ дүгнэлт гаргасан байна.

Аудитаар нийт 2,152.1 сая төгрөгийн 21 алдаа, зөрчил илрүүлснээс 237.1 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 1,862.7 сая төгрөгийн 12 зөрчлийг арилгуулах албан шаардлага, 52.2 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэг 37 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 19 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 18 санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргасан. Дүгнэлт гаргасан байгууллагуудаас “Өөрчлөлтгүй” 17, “Хязгаарлалттай” 1 /Аймгийн ЗДТГ/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3,331.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 290.9 сая төгрөгийн 38 алдааг аудитын явцад залруулж, 17.6 сая төгрөгийн 17 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 894.1 сая төгрөгийн 70 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 2,128.6 сая төгрөгийн 15 алдаа, зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 6 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд аудит хийж, 3 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан 3 санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргасан. Дүгнэлт гаргасан байгууллагуудаас “Өөрчлөлтгүй” 2 /Дундговь-Ус ОНӨААТҮГ, Өлзийт Мандал ӨЭМТ/, “Хязгаарлалттай” 1 /”Мандалын гэгээ ХТГ” ОНӨААТҮГ/ дүгнэлт гарсан байна.

Аудитаар нийт 2,428.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 327.5 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,720.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 16 албан шаардлага, 379.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж хүргүүлсэн.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 32 тусгай сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа. Аудитаар нийт 5,348.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 403.6 сая төгрөгийн 24 алдааг аудитын явцад залруулж, 78.0 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 2,952.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 18 албан шаардлага, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, 1,613.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 12 зөвлөмж хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 1,410.4 сая төгрөгийн 16 алдаа, зөрчил¹ илэрснээс 38.1 сая төгрөгийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



төлбөрийн акт тогтоож, 1,372.3 сая төгрөгийн зөрчил арилгах хугацаатай 12 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

1. Иргэдийн бэлнээр төлсөн 12.9 сая төгрөгийн нүүрсний үнийг холбогдох дансанд бүрэн төвлөрүүлээгүй, дутагдуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 35.2-т (*Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна*), 35.3-т (*Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ*) заасныг;
2. Техник хяналтын зардлаас Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 83 дугаар тушаалын хавсралтыг зөрчин 12.8 сая төгрөгийн зураг төсвийн мөнгө шилжүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д (*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*), 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*) заасныг;
3. Техник хяналтын зардлаас 0.1 сая төгрөгийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хангамжийн материалын зардал илүү шилжүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д (*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*), 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*), Барилга хот байгуулалтын сайдын тушаал “Барилгын захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” -ын 2.1.4-т (*Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлыг гүйцэтгэгч байгууллагын дансанд бүрэн шилжүүлэх, хяналтын зардлыг зориулалт бусаар захиран зарцуулахгүй байх*) заасныг;
4. Засаг дарга сангаас орон нутгийн хөрөнгө оруулалтаар батлагдсан ТАХ-ны чанарын баталгаанд 12.3 сая төгрөгийг суутган баталгааны дансанд шилжүүлсэн боловч тооцооллын алдааны улмаас “Баяндөхөмийн хурд” ХХК-д чанарын баталгааг илүү шилжүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42.5-д (*Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно*) заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, Засаг дарга сан, Техник хяналтын сангуудад илэрсэн дээрх зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоож, сангийн төсөв захирагч нарт хүргүүлээ.

3.2 Албан шаардлага

1. Техник хяналтын сангаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой 92.8 сая төгрөгийн зардлыг шилжүүлж, сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т (*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*), мөн хуулийн 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*), 41.2.2-т (*батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах*), Барилга хот байгуулалтын сайдын “Барилгын захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” тушаалын 2.1.4-т (*Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлыг гүйцэтгэгч байгууллагын дансанд бүрэн шилжүүлэх, хяналтын зардлыг зориулалт бусаар захиран зарцуулахгүй байх*) заасныг;
2. Техник хяналтын сангийн санхүүгийн тайлан дахь 119.5 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг*



- баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.1.8-д (*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх*) заасныг;
3. Техник хяналтын сангийн үр дүнгийн тайланд 54.6 сая төгрөгийн зардлыг бараа материалын зардлаар тайлагнаагүй, шууд зардлаар тайлагнасан, шатахууны тооллого тооцоо бодож баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 13.7-д (*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*), 20.2.3-т (*Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2-т (*Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана*), 73.2-т (*Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана*) заасныг;
 4. Техник хяналтын сангаас Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж төсвийн хөрөнгөөр 2.9 сая төгрөгийн ажлын хувцас худалдаж авсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т (*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1-т (*Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно*) заасныг;
 5. Техник хяналтын сангаас Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж төсвийн хөрөнгийг байгууллагын үйл ажиллагааг сурталчлах үйл ажиллагаанд 0.8 сая төгрөгийг зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т (*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4-т (*Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх*) заасныг;
 6. Техник хяналтын сангийн тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 300.0 сая төгрөгийн мэдээллийг огт байршуулаагүй, байршуулах арга хэмжээ авч ажиллаагүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-т (*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*), 4.1.3-т (*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*), 7.1-д (*заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй*) заасныг;
 7. Засаг дарга сангийн санхүүгийн тайлан дахь 31.7 сая төгрөгийн өндөр насжилттай, эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэртэй холбоотой авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-д (*Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ*), Захиргааны ерөнхий хуулийн 103.2-т (*Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна*), Иргэний хуулийн 498.5-д (*Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй*), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.1.8-д (*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх*), Төсвийн тухай хуулийн 16.5.2-д (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*) заасныг;
 8. Энержи Ресурс ХХК-ийн хамтын ажиллагааны хүрээнд үнэ төлбөргүй олгосон баяжуулсан нүүрсний тээвэрлэлттэй холбоотой 561.6 сая төгрөгийн зардлыг иргэдээс хураан авсан



- боловч уг санхүүгийн гүйлгээг ТЕЗ-ийн тайланд тусгаж, зарцуулалтыг тайлагнаагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25.4-т (*Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно*), 25.7-д (*Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана*) заасныг;
9. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын орон тоог 472 байхаар төлөвлөж, Сангийн ямаар хянуулсан ч Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг баримтлалгүй 489 төрийн албан хаагчтай байхаар баталсан. Энэ нь Монгол Улсын Их Хурлын “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад (*Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ*), Монгол Улсын Сангийн сайдын орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийн 2.2-т (*...Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах байгууллагуудын чиг үүрэгт дүн шинжилгээ хийн бүтэц, зохион байгуулалтын оновчтой хувилбарыг сонгож, нэгтгэн зохион байгуулах замаар Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд аймгийн суурь зарлагад туссан төсөв, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулах*) заасныг;
 10. Архивын хэлтсийн 82.5 сая төгрөгийн зардалтай санхүүгийн тайланг аудитаар оруулаагүй, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтыг зөрчсөн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.1-т (*төсвийн шүүд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх*) заасныг;
 11. Мал хамгаалах сангийн санхүүгийн тайлан дахь насжилт өндөртэй 112.4 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*) заасныг;
 12. Төсвийн хөрөнгөөр онцгой комиссын гишүүдэд 13.4 сая төгрөгийн хувцас худалдан авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1-т (*Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно*) заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дундговь аймгийн Мал хамгаалах сан, Техник хяналтын сан, Засаг дарга санд илэрсэн 1,372.3 сая төгрөгийн зөрчлүүдийг арилгах хугацаатай албан шаардлагыг Дундговь аймгийн Засаг дарга, Мал хамгаалах сан, Техник хяналтын сангийн төсөв захирагч нарт хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 91.4 хувийг залруулагдаагүй, 8.6 хувийг залруулсан алдаа эзэлж байна.

Нийт 13,412.0 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчлийн 68.8 хувь буюу 9,231.0 мянган төгрөг нь нийцлийн аудитын асуудал, үлдсэн 31.2 хувь буюу 4,181.0 мянган төгрөг нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил илэрчээ.

Харин санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 3,744.0 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 4.6 дахин их тул “ХЯЗГААРЛАЛТТАЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДУА-2026/1/НА-СТА-ТЕЗ



4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын алдааны нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		НББ-ийн бодлогыг буруу хэрэгжүүлсэн		Математик тооцоололтой холбоотой		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
											Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	-	-									-	-		
ТТЗ	5	237.1	1	13.2	4	223.9					5	237.1		
ТШЗ	38	290.9	14	122.9	9	37.7	10	124.2	5	6.1	38	290.9		
ОНӨААТҮГ	5	327.5	2	71.2	3	256.4					5	327.5		
ТЗС	24	403.6	7	10.5	2	248.4	7	75.6	8	69.1	24	403.6		
Дүн	72	1,259.1	24	217.8	18	766.3	17	199.8	13	75.2	72	1,259.1	0	0

Нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын зөрчлийн нэгтгэл :

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	10	1,010.8	4	38.1	6	972.7						
ТТЗ	11	1,867.8			8	1,855.9	3	12.0				
ТШЗ	72	602.1	16	17.1	52	539.4	4	45.7				
ОНӨААТҮГ	15	145.7	1	0.5	10	140.8	4	4.5				
ТЗС	23	554.6	11	78.0	10	425.1	2	51.5				
Нийт дүн	131	4,181.1	32	133.7	86	3,933.8	13	113.6	-	-	-	-



Нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын нийцлийн аудитын асуудал :

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
ТЕЗ	1	300.0			1	300.0						
ТТЗ	1	-			1							
ТШЗ	4	211.2			3	91.1	1	120.1				
ОНӨААТҮГ	2	113.5			1	23.0	1	90.5				
ТЗС	4	1,253.9			2	491.9	2	762.1				
ДҮН	12	1,878.6	-	-	8	906.0	4	972.6	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
ТЕЗ	5	99.6			5	99.6						
ТТЗ	4	47.2			3	6.9	1	40.3				
ТШЗ	26	2,227.0	1	0.5	15	263.6	10	1,962.9				
ОНӨААТҮГ	7	1,842.1			5	1,557.1	2	285.0				
ТЗС	17	3,136.5			6	2,035.0	8	800.0	3	301.5		
ДҮН	59	7,352.4	1	0.5	34	3,962.2	21	3,088.2	3	301.5	-	-
НИЙТ ДҮН	71	9,231.0	1	0.5	42	4,868.1	25	4,060.8	3	301.5	-	-



Хавсралт №1

4.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

(сая.төгрөгөөр)

Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр						Нийт алдаа, зөрчил		Залруулсан		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		Хариуцлага тооцох албан шаардлага	
	Нийт хамрагдсан	Түүвэрт хамрагдсан	Дүгнэлт																	
			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТЕЗ	-						16	1,410.4			4	38.1	12	1,372.3						
ТТЗ	15		11	4			21	2,152.1	5	237.1		-	12	1,862.7	4	52.2				
ТШЗ	37	19	17	1			140	3,331.2	38	290.9	17	17.6	70	894.1	15	2,128.6				
ОНӨААТҮГ	6	3	2	1			29	2,428.8	5	327.5	1	0.5	16	1,720.8	7	379.9				
ТЗС	32	32					68	5,348.7	24	403.6	11	78.0	18	2,952.0	12	1,613.6			3	301.5
НИЙТ ДҮН	90	54	30	6	-	-	274	14,671.2	72	1,259.2	33	134.2	128	8,801.9	38	4,174.4	-	-	3	301.5



Хавсралт №2

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн актын нэгтгэл

/төгрөгөөр/

№	Аудитын нэр	Аудитын код	Зөрчлийн товч утга	Мөнгөн дүн
1	АЙМГИЙН ЗДТГАЗАР - Санхүү, нийцлийн аудит	ДУА-2026/17/НА-СТА-ТШЗ	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөд хүндэтгэлийн хүлээн авалт хийхдээ тогтоосон норматив зардлаас илүү зарцуулсан.	3,590,000.00
2	АЙМГИЙН ИТХ - Санхүү, нийцлийн аудит	ДУА-2026/01/НА-СТА-ТШЗ	Зөвлөгөөнөөр ирсэн зочид төлөөлөгч, хүлээн авахдаа хүндэтгэлийн зоог барих зардлыг тогтоосон норматив зардлаас илүү зарцуулсан.	423,300.00
3	Байгаль орчны газар - Санхүү, нийцлийн аудит	ДУА-2026/75/НА-СТА-ТШЗ	Албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны мөнгийг давхардуулан олгосон	338,000.00
4	Гурвансайхан сумын ЗДТГ - Санхүү, нийцлийн аудит	ДУА-2026/21/НА-СТА-ТШЗ	Албан томилолтын зардалтай давхардуулан хоолны мөнгө олгосон	210,000.00
5	Гурвансайхан сумын ЗДТГ - Санхүү, нийцлийн аудит	ДУА-2026/21/НА-СТА-ТШЗ	Нууц хамгаалах чиг үүргийг хариуцуулахдаа тагнуулын байгууллагаас зөвшөөрөл авалгүй нэмэгдэл олгосон.	1,429,629.00
6	ДУ ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР - Санхүү, нийцлийн аудит	ДУА-2026/84/НА-СТА-ТШЗ	Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан	510,000.00
7	ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ИТХУРАЛ - Санхүү, нийцлийн аудит	ДУА-2026/07/НА-СТА-ТШЗ	Байгууллагын дарга ахмадын сангаас өөртөө тушаал гаргаж гарын бэлгийн мөнгө шилжүүлж авсан	50,000.00
8	ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ИТХУРАЛ - Санхүү, нийцлийн аудит	ДУА-2026/07/НА-СТА-ТШЗ	Багийн засаг даргаар ажиллах хугацаанд БИНХ-ын даргын үүргийг давхар гүйцэтгэж урамшуулал авсан	515,615.00
9	Дундговь аймгийн Сум дундын ойн анги - Санхүү, нийцлийн аудит	ДУА-2026/89/НА-СТА-ТШЗ	Хоолны хөнгөлөлтийг албан томилолттой давхардуулан олгосон.	270,000.00
10	Сайхан-Овоо сумын ЗДТГ - Санхүү, нийцлийн аудит	ДУА-2026/29/НА-СТА-ТШЗ	Орон нутгийн өөрийн өмчийн түрээсийн орлогын 40%-ийг төвлөрүүлээгүй	1,315,600.00
11	Хулд сумын ЗДТГ - Санхүү, нийцлийн аудит	ДУА-2026/30/НА-СТА-ТШЗ	Эрх бүхий албан тушаалтан өөртөө захирамж гарган, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон.	294,700.00
